

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
В.ШООВДОРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 4, 5, 6 дугаар зорилт)							
1.	Арга хэмжээ 1.1. Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах	- Тушаалын огноо, дугаар.	0	100	Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөрийн төслийг боловсруулж, Захиргаа, удирдлагын газрын 02 дугаар сарын 12-ны өдрийн 02/18 дотоод албан бичгээр, төв болон орон нутаг дахь нэгжийн газар, хэлтсийн дарга нараас 02 дугаар сарын 17-оос 24-ний өдрүүдэд файлаар тус тус санал авсан. Дээрх ирүүлсэн саналын нэгтгэл, хөтөлбөрийн төслийг Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцүүлээ. Хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг зохион байгуулахаар байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/107 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд байгууллагын албан хаагчдад болон цахим хуудсанд нээлттэй байршуулж, танилцах боломжийг бүрдүүлсэн.	01-03	
2.	Арга хэмжээ 1.2. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих	- Батлуулсан төлөвлөгөө; - Хэрэгжилтийн хувь.	90.2	50	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 24 арга хэмжээний хүрээнд 44 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулж, батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу төв, хилийн боомт орон нутаг дахь нэгжийн төрийн	01-12	

					тусгай болон төрийн үйлчилгээний нийт 266 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, бусад нарийн мэргэшлийн оношилгоо шинжилгээнд хамруулахаар санал хүсэлтийг албан хаагчдаас 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд авч, хамрагдах шинжилгээг төрөлжүүлэн, Улсын төв Нэгдүгээр эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэг, бусад үзлэг шинжилгээг зохион байгуулах саналыг 05 дугаар сарын 12-ны өдрийн 02/925 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төв байгууллагаас “Сити фарм дэнк” ХХК-тай хамтран 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд 98 албан хаагчийг эрдсийн шинжилгээнд хамруулж, эмчийн зөвлөгөө авсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар Төрийн тусгай албан хаагчийн Нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хилийн боомт, орон нутаг дахь 5 нэгжээс 66, “Хавдаргүй Монгол эмэгтэй” төслийн хүрээнд хийсэн үзлэгт 7 нийт 73 албан хаагчийг хамруулсан. Байгууллагын даргын 2024 оны А/407 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”-ыг батлуулж, ажлын онцлог, чиг үүргээс хамаарч зохион байгуулалтын нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу 38 албан хаагчийг 7 хоногийн 1 өдөр зайнаас ажиллуулж байна. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 4.17, 4.18, 4.19-р зүйлд заасны дагуу албан хаагчийн шалтгаан нөхцөлийг нь харгалзан 47 албан хаагчид давхардсан тоогоор олговортой чөлөө 36, олговоргүй чөлөө 23 нийт 59 удаа олгосон байна. Байгууллагын даргын 2025 оны Б/16, Б/18, Б/79 дүгээр тушаалаар гэр бүлийн гишүүн нь нас барсан 3 албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тусламж олгуулсан.		
3.	Арга хэмжээ 1.3. Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны сургалтын	- Батлуулсан төлөвлөгөө; - Хэрэгжилтийн хувь	93.3	50	Төрийн албан хаагчийн 2025 оны сургалтын төлөвлөгөөг 6 арга хэмжээний хүрээнд 35 үйл ажиллагааг төлөвлөж, байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 42	01-12	

	төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих				удаагийн сургалтад давхардсан тоогоор 1800 гаруй албан хаагч хамрагдсан. Тухай бүр сургалтын удирдамж, явц үр дүнд хяналт тавьж ажилласан.		
4.	Арга хэмжээ 1.4. Удирдах ажилтан, ахлах мэргэжилтнүүд, хяналтын улсын байцаагчийн эрх олгох, чиглүүлэх зэрэг зорилтот сургалт зохион байгуулах, хяналт тавих	- Батлуулсан удирдамж, сургалтын хөтөлбөр; - Хэрэгжилтийн хувь	Зорилтот сургалт-4; Хамрагдсан албан хаагчийн тоо-79.	50	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Удирдах албан тушаалтны нэгдсэн сургалт зохион байгуулах тухай" А/59 дүгээр тушаалаар 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд төв, хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн удирдах албан тушаалтны цугларалтыг зохион байгуулсан. Цугларалтад төвийн нэгжийн дарга, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга, хяналтын улсын ахлах байцаагч, виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, захиргааны ахлах мэргэжилтэн зэрэг 34 албан хаагч хамрагдсан.	01-12	
5.	Арга хэмжээ 1.5. Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах, сэлгэн ажиллуулахад сонсох ажиллагаа хийсэн байх	- Сонсох ажиллагаанд хамрагдсан албан хаагчийн тоо; - Боловсруулж, батлуулсан тушаалын тоо.	Сахилгын шийтгэл-17; Сэлгэн-3.	100	Тайлант хугацаанд (2025.01.02-06.06) Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах 8 төрийн албан хаагчтай, мөн нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах 10 төрийн жинхэнэ албан хаагчтай Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийж, тэмдэглэлийг албажуулсан.	01-12	
Зорилт 2. "Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын болон байгууллагын эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг гүйцэтгэх;							
6.	Арга хэмжээ 2.1. Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах	- Батлуулсан төлөвлөгөө; Хэрэгжилтийн хувь.	100	50	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг салбар зөвлөлийн 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 19 үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд салбар зөвлөлийн 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилд 85 хувьтай. Эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 25-ны өдөрт багтаан Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хүргүүлэх юм.		
	Арга хэмжээ 2.2. Монгол Улсын Хилийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу хилийн боомтод үүрэг гүйцэтгэх орон нутаг	Уламжилсан албан бичгийн огноо, дугаар.	-	50	Байгууллагын даргын баталсан 01-02/31 удирдамжийн дагуу 06 дугаар сарын 03-ны өдөр "Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл" сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Б.Нарантулгатай хамтран зохион байгуулав. Сургалтад төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн		

	дахь нэгжийн ачааллыг тэнцвэржүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний шуурхай, ил тод байдлыг хангах зорилгоор ажил үүргийн хуваарь, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт хийх, процессын дахин инженерчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх			150 орчим албан хаагчийг хамруулсан. Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын ажлын ачааллыг бууруулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор виз, визийн зөвшөөрөл, албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, оршин суух үнэмлэх дахин авах, паспортын мэдээлэл өөрчлөх, хаягийн өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хасалтын хүсэлтийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 6 газар, 4 хэлтсийн албан хаагчдаар гүйцэтгүүлэхээр байгууллагын даргын 2025 оны А/63 тушаалаар 31, А/114 тушаалаар 8, А/145 тушаалаар 43, А/158 тушаалаар 14, нийт 96 албан хаагчийг хүсэлтийг цахим системд шалгах эрх олгосон. Мөн төвийн үндсэн чиг үүргийн нэгжийн албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг ажлын байранд сургаж, дадлагажуулах зорилгоор Виз зөвшөөрлийн газарт 24, Зөрчил шалган шийдвэрлэх газарт 11, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэст 2, Мэдээллийн технологийн хэлтэст 1, орон нутгийн Дорноговь аймаг дахь газарт 1, нийт 39 албан хаагчийг байгууллагын даргын 8 удаагийн тушаалаар 1-3 сарын хугацаатай ажиллуулж сургалаа.		
Арга хэмжээ 2.3. Сул орон тоог нээлттэй зарлуулж, тусгай шалгалтыг зохион байгуулан албан тушаалын сул орон тоог нөхөх	- Зарлуулсан сул орон тоо; - Зохион байгуулсан тусгай шалгалтын тоо; - Нөхсөн албан тушаал; - ТАЗ-д хүргүүлсэн цахим тайлан.	- Сул орон тоо-33; - Тусгай шалгалт-8; - Нөхсөн орон тоо-24; - Цахим тайлан-8.	100	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны жилийн тайлан, холбогдох судалгааг маягтын дагуу нэгтгэж, байгууллагын даргын 01 дүгээр сарын 09-ны өдрийн 01/53 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газар хүргүүлэв. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, сул орон тоог нөхсөн тухай 2024 оны үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд болон төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад нээлттэй танилцуулах зорилгоор erp.e-mongolia.mn цахим сүлжээнд байршууллаа. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн тусгай албаны гүйцэтгэх 18 албан тушаалын сул орон тооны 3		

					удаагийн зарыг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Дээрх журмын 4.3, 4.4-т зааснаар төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөгдөөгүй 8 сул орон тоог Төрийн албаны зөвлөлд захиалга хүргүүлэн www.csc.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, 2 удаагийн сонгон шалгаруулалт зохион байгуулаад байна. Сонгон шалгаруулалтад 2 удаа нээлттэй зарласан Хойд бүс дэх газрын мэдээллийн технологийн мэргэжилтэн, Мэдээллийн технологийн хэлтсийн сүлжээний болон өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтний 3 сул орон тоонд шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн хяналтын улсын байцаагчийн 2 орон тоонд өрсөлдсөн иргэдийн шалгалтын дүн босго оноонд хүрээгүй.		
	Арга хэмжээ 2.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарах өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах	- Салбар зөвлөлийн тогтоолын огноо, дугаар; - Хамрагдсан албан хаагчийн тоо.	- Тангараг өргөх ёслол 2 удаа; - Албан хаагч-27.	-	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн, туршилтаар ажиллуулах хугацаа дууссан төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа 11 албан хаагчийг Төрийн албаны өдөр (07 дугаар сарын 03)-ийг тохиолдуулан тангараг өргүүлэхээр судалгааг нэгтгээд байна.		
	Арга хэмжээ 2.5. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны явц, үр дүнг албан хаагчдад мэдээлэх	- Байршуулсан мэдээлэл.	4	4	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны жилийн тайлан, холбогдох судалгааг маягтын дагуу нэгтгэж, байгууллагын даргын 01 дүгээр сарын 09-ны өдрийн 01/53 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газар хүргүүлэв. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, сул орон тоог нөхсөн тухай 2024 оны үйл ажиллагааны болон 1 дүгээр улирлын мэдээллийг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд болон төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад нээлттэй танилцуулах зорилгоор erp.e-mongolia.mn цахим сүлжээнд тус тус байршууллаа.		
	Арга хэмжээ 2.6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх, khutulbur.iaac.mn	- Батлуулсан төлөвлөгөө; - Хэрэгжилтийн хувь.	91.3	50	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он) болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг khutulbur.iaac.mn цахим хуудсанд 01 дүгээр сарын 28-ны өдөр илгээж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргад болон Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх		

цахим хуудсанд тайлагнах				үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн даргад байгууллагын даргын 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/247, 01/248 албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн даргад хүргүүлсэн дээрх албан бичгийн хавсралтаар хөтөлбөр, төлөвлөгөөний 2025 оны тайланд хууль тогтоомж, байгууллагын чиг үүрэгт хамааралгүй үндэслэлээр хасах, нэмэлтээр тусгуулах зорилт, арга хэмжээний саналыг нэгтгэж хүргүүлсэн. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах 2 төлөвлөгөөг нэгжийн даргаар хянуулан, байгууллагын даргаар батлуулсан. 1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө; 2. Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө. Баталсан төлөвлөгөөг төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт Захиргаа, удирдлагын газрын 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/14 дотоод албан бичгээр цахимаар хүргүүлж, байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Салбар ЭБАТ болон мэдүүлэг гаргах албан тушаалтанд нийтдээ 2 зөвлөмж, чиглэл өгсөн дотоод албан бичиг 3 удаа хүргүүлж, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангасан. Эхний хагас жилийн дүнгээр Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 3 төлөвлөгөө, 1 чиглэлийн хэрэгжилт 90 хувьтай.		
Арга хэмжээ 2.7. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх хүрээнд албан тушаалд шинээр томилох, шилжүүлэн	- ХАСУМ мэдүүлсэн албан хаагчийн тоо; - Тайлан хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар.	- ХАСУМ-86; - ХАСХОМ-210	100	Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 36 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж хэвшлээ. Үүнд: Албан тушаалын тусгай шалгалтад		

	ажиллуулахдаа ХАСУМ хянуулах, 2024 оны тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх				тэнцэж шинээр томилогдох 3, төрийн бусад байгууллагаас шилжүүлэн ажиллуулах 4, нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах 29, албан үүрэг түр орлон гүйцэтгэгчээр томилох 3, нийт 39 иргэн, төрийн жинхэнэ албан хаагчийн ХАСУМ-г "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем"-д шинээр үүсгэж, мэдээллийг хянаж баталгаажуулан Авлигатай тэмцэх газарт хянуулахаар 12 удаагийн албан бичгээр хүргүүлсэн. "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем"-д үүсгэсэн мэдүүлэг гаргах 209 албан тушаалтны 2024 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, байгууллагын даргын 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/478 албан бичгээр батлагдсан маягт, зөвлөмж зааврын дагуу нэгтгэсэн "ХАСХОМ-ийн 2024 оны тайлан"-г хавсралтаар, мөн ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг цахимаар тус тус хүргүүлсэн.		
	Арга хэмжээ 2.8. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах	- Батлуулсан төлөвлөгөө; - Хэрэгжилтийн хувь.	0	50	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд "Эрсдэлд суурилсан авлигын эсрэг төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, байгууллагын даргаар 02 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөг байгууллагын чиг үүрэгт хамааралтай 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд эхний хагас жилийн дүнгээр хэрэгжилт 80 хувьтай. Төлөвлөгөөний дагуу Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар байгууллага, нэгжийн албан тушаалтны үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг бүрдүүлэх зорилгоор байгууллагын даргын 05 дугаар сарын 27-ны өдрийн А/247 дугаар тушаалаар "Олон нийтийн хяналтад хамруулах чиглэл"-ийг баталсан. Тушаалыг төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд Захиргаа, удирдлагын газрын 05 дугаар сарын 27-ны өдрийн 02/72 дотоод албан бичгээр хүргүүлсэн.		
	Арга хэмжээ 2.9. Байгууллагын дотоод	- Хэрэгжилтийн хувь	0	50	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод		

	аюулгүй байдлыг хангах 2025 оны үйл ажиллагаанд тусгасан хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах			аюулгүй байдлыг хангах 2025 оны ажлын төлөвлөгөө"-ний хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах зорилтод тусгасан 3 арга хэмжээний хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. 1.Төрийн албаны тухай хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага, ажлын туршлага, ур чадварыг харгалзан төрийн тусгай албаны гүйцэтгэх хяналтын улсын ахлах байцаагч, ээлжийн ахлах мэргэжилтний албан тушаалд 6 албан хаагчийг дэвшүүлэн томилсон. Мөн гадаад сургалтад 18 албан хаагчийг хамруулж, холбогдох журмын дагуу 26 (төрийн одон медальд-8, салбарын тэргүүнд-9, яамны жуух бичигт-8, Сангийн яамны жуух бичигт-1) албан хаагчийг тодорхойллоо. 2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 02 дугаар сарын 03-04-ний өдрийн хооронд зохион байгуулсан удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалтын үеэр ёс зүйн зөрчил болон авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн нэгжийн хэмжээнд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн нийт 22 албан хаагчийг санал асуулгад хамрууллаа. Мөн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж"-ийн талаар албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийн мэдлэгийг шалгах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 03 дугаар сарын 21-ний өдөр төв байгууллагын 79, 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газрын 25 нийт 104 албан хаагчийг хамруулсан. 3.Төвийн үндсэн чиг үүргийн нэгжийн албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг ажлын байранд сургаж, дадлагажуулах зорилгоор Виз зөвшөөрлийн газарт 24, Зөрчил шалган шийдвэрлэх газарт 11, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэст 2, Мэдээллийн технологийн хэлтэст 1, орон нутгийн Дорноговь аймаг дахь газарт 1, нийт 39 албан хаагчийг байгууллагын даргын 8 удаагийн тушаалаар 1-3 сарын хугацаатай сургалаа.		
--	--	--	--	---	--	--

Зорилт 3. Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.							
	Арга хэмжээ 3.1. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хүлээн авсан албан бичиг, хариутай албан бичиг, албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариуг өгөх, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	- edoc.mojha.gov.mn цахим системээр хүлээн авсан баримт бичиг, өргөдөл гомдлын тоо; - Шийдвэрлэлтийн хувь; - Хянасан тушаал, төлөвлөгөө, удирдамж, албан бичгийн төслийн тоо.	100	100	Тайлант хугацаанд хариуцсан чиг үүргийн дагуу А-тушаал 5, Б-тушаал 51, төлөвлөгөө 7, албан бичиг 55, илтгэх хуудас 7, дотоод албан бичиг 18-г тус тус боловсруулж, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж батлуулсан. Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн боловсруулсан нийт А-тушаал 8, Б-тушаал 68, 5 удирдамж, хөтөлбөр, 15 илтгэх хуудас 28, дотоод албан бичиг 14, бусад төрийн байгууллагад явуулах 57 албан бичгийн төслийг тухай бүр хянаж, албан бичгийн стандарт болон монгол хэл бичгийн найруулга зүй, зөв бичгийн дүрмийн алдааг засаж, залруулсан. Тайлант хугацаанд бие даан 21 албан хаагчийн өргөдөл, хүний нөөцийн дүнгээр нийт 33 өргөдлийг хүлээн авч, 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг холбогдох иргэн, албан хаагчид тухай бүр албан бичгээр болон амаар өгсөн.		
	Арга хэмжээ 3.2. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3-т заасан мэдээллийн нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр www.immigration.gov.mn цахим хуудсанд байршуулсан байх	- Байршуулсан мэдээлэл.	Тухай бүр	100	Хүний нөөцийн талаарх хуульд заасан 7 төрлийн мэдээлэлд дараах байдлаар нэмэлт мэдээлэл оруулсан. 1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл-ТАЗ-ын цахим хуудас руу шууд холбогддог бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжин, сэлгэн ажиллуулах 3 удаагийн зар; 2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам-нэмэлт мэдээлэл ороогүй; 3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм- Ёс зүйн дэд хороо байгуулсан тушаал нэмэлтээр; 4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам- нэмэлт мэдээлэл ороогүй; 5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ- Салбар зөвлөлийн 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудасны “хүний нөөц”-“тайлан” цэсэд, мөн Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөр, хөтөлбөр хэрэгжүүлэх 2 төлөвлөгөөг тус тус нэмэлтээр; 6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам-нэмэлт мэдээлэл ороогүй.		

	Арга хэмжээ 3.3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулах	- Чиглүүлэх сургалтын тоо; - Хамрагдсан албан хаагчийн тоо	2 удаа, 33 албан хаагч	50	Байгууллагын ЭБАТ-аас чиглүүлэх сургалтын 14, хяналтын улсын байцаагчийн чадавхжуулах сургалтын 9 албан хаагчид "Авлигаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт танхимын сургалт 03, 05 дугаар сард хийсэн.		
--	--	---	---------------------------	----	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ажиллах	- Боловсруулж, батлуулсан баримт бичгийн тоо; - Оролцсон хурлын тоо.	-	100	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороотой мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий холбогдох албан хаагчдыг арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зорилгоор удирдамжийн төслийг боловсруулж, байгууллагын даргын 03 дугаар 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар батлуулсан. Удирдамжийн дагуу орон нутагт ажиллах чиглэлийн талаар Ёс зүйн дэд хорооны 03 дугаар сарын 13-ны өдрийн хуралд танилцуулсан. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд нийт албан хаагчдаас "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж" агуулгаар сорил авах болон тухайн нэгжид 5-аас доошгүй жил ажилласан, сахилгын болон ёс зүйн шийтгэлгүй, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн төрийн тусгай албан хаагчийг нэр дэвшүүлж, хамт олны олонхын санал авсан нэг албан хаагчийн нэрийг Ёс зүйн дэд хороонд 01 дүгээр сарын 31-ний өдөрт багтаан ирүүлэх агуулга бүхий дотоод албан бичгийн төслийг боловсруулж, Ёс зүйн дэд хорооны даргаар хянуулж, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлсэн. Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл	01-12	

					ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчдыг томилох тушаалын төслийг боловсруулж, байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/106 дугаар тушаалаар батлуулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Эхний хагас жилд Ёс зүйн дэд хорооны 3 удаагийн хуралд бүрэн оролцсон.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Үнэлгээний хороонд ажиллах	- Ажилласан Үнэлгээний хорооны тоо	-	100	Тайлант хугацаанд дараах 3 Үнэлгээний хороонд ажилласан. Байгууллагын даргын 2024.12.16-ны өдрийн А/567 дугаар тушаалаар байгуулсан "Хилийн боомтод виз олгоход шаардагдах тоног төхөөрөмж нийлүүлэх" гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, 2025.01.15-ны өдрийн тушаал А/23 дугаар тушаалаар байгуулсан "Интернэт болон сувгийн холболтын үйлчилгээ" үзүүлэх гүйцэтгэгч шалгаруулах Үнэлгээний хорооны гишүүн, 2025.01.15-ны өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан "Мэдээлэл технологийн үйлчилгээ" үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгч шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, 2025.01.15-ны өдрийн А/23 дугаар тушаалаар байгуулсан "Виз мэдүүлгийн киоск машины программ хангамжийн хөгжүүлэлт, гадаадын иргэний виз бүртгэлийн нэгдсэн системд нэмэлт хөгжүүлэлт хийх" зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгч шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар тус тус ажиллаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулах, зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, захиалагчид зөвлөмж хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Байгууллагын даргын 2024.12.16-ны өдрийн А/567 дугаар тушаалаар байгуулсан "Хилийн боомтод виз олгоход шаардагдах тоног төхөөрөмж нийлүүлэх" 5 багц тендерээс амжилтгүй болсон "Хяналтын камер, иж бүрдэл" худалдан авах 1 багцын тендерийг 4 удаа зарлаад байна.	01-06	
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн	- Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо	-	100	Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяныг зохион байгуулах тухай 15 дугаар тушаалын дагуу аяны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 12 үйл	01-12	

	үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх				ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулж, байгууллагын даргаар 02 дугаар сарын 24-ний өдөр батлуулж, Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт цахимаар илгээсэн. Аяны тайланг 06 дугаар сарын 20-ны дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх юм. “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт хүний нөөцийн аудитын дүгнэлтийг хэрэгжүүлэх Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3, 5.3.11, 5.3.18-д заасан зорилт арга хэмжээний хүрээнд 9 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулж, байгууллагын даргаар 03 дугаар сарын 12-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөг холбогдох нэгж, албан хаагчид цахимаар хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 02 дугаар тушаалаар яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлтэй хамтран Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах зорилгоор 21 аймгийн 330 сумдад ажиллах дэд ажлын хэсэгт 03 дугаар сарын 17-31-ний өдрүүдэд Ховд аймгийн Дарви, Мөст, Цэцэг, Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Бугат, Шарга, Баян-Уул сумдад албан томилолтоор ажиллаж, 1620 орчим төрийн албан хаагч хувийн хэрэгтэй танилцаж, үүнээс 90 орчим төрийн захиргааны албан хаагчийн томилгоонд хяналт шалгалт хийсэн.		
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Байгууллага, салбарын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд түгээх	- Түгээсэн мэдээллийн тоо	-	100	Тайлант хугацаанд (2025.01.02-2025.06.06) байгууллагын болон салбарын яамны үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээний Гадаадын иргэн, харьяатын газар \ImmigrationAgency Of Mongolia\ хаягаас өөрийн мессенжер хаягт 133 удаа түгээсэн.	01-12	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. “Монгол бичиг”-ийн цахим сургалтад хамрагдах	- 1, 2, 3-р түвшний сургалтад хамрагдсан байх; - Гэрчилгээ авсан байх.	-	100	Зангиа.мн-д цахим хуудасны монгол бичгийн анхан, дунд, ахисан түвшний 1-3 дугаар шатны цахим сургалтад 04, 05 дугаар сард судалж, 70 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй тэнцэж, гэрчилгээ авсан.	03-06	
2.	Арга хэмжээ 2. “Хяналт шинжилгээ, үнэлгээ”-сэдэвт цахим сургалтад хамрагдах	- 1, 2, 3-р түвшний сургалтад хамрагдсан байх; - Гэрчилгээ авсан байх.	-	-	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй		ХХБ
3.	Арга хэмжээ 3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулах	- Чиглүүлэх сургалтын тоо; - Хамрагдсан албан хаагчийн тоо	3 удаа, 31 албан хаагч	50	03 дугаар сарын 24-ний өдрөөс 26-ны өдрүүдэд болсон чиглүүлэх сургалтад Ховд, Говь-Алтай аймагт Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэгт албан томилолтоор ажиллаж байсан тул хариуцсан чиг үүргийн дагуу сургалт зохион байгуулж, амжаагүй.	03-12	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүний нөөц, сургалт хариуцсан
ахлах мэргэжилтэн
(албан тушаал)


..... /В.Шоовдор/
(нэр, гарын үсэг)

2025.06.06

(огноо)